**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 06 өдөр Дугаар А/144 Номгон

"Сэргээгдэх эрчим хүч" үзэсгэлэн, хэлэлцүүлэгт хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг эрчимжүүлж үзэсгэлэн, хэлэлцүүлэг зохион байгуулах арга хэмжээнд 595,500 (Таван зуун ерэн таван мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

2.Тус үзэсгэлэн, хэлэлцүүлгийн арга хэмжээнд холбогдох төрийн байгууллага, аж ахуй нэгж, олон нийтэд мэдээлж үр дүнтэй зохион байгуулж, сурталчилж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА Э.ЭНХБАТ

02001039З

D:\2026\1.Zakhiramj\Zahiramj 01.docx

Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн ...А/149.... дүгээр захирамжийн хавсралт

## “СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ” ҮЗЭСГЭЛЭН, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зардлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Хулдаасан хэвлэл | ш | 1 | 188000 | 188000 |
| 2 | Үдийн хоол | хүн | 5 | 55000 | 275000 |
| 3 | Цайны зардал | ш | - | 150,000 | 150,000 |
| **Нийт дүн** | | | | | **595,500** |

______oOo______